



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Улсын үзлэг тооллогын бэлтгэл
хангах, зарим албан хаагчдыг
томилолтоор ажиллуулах тухай

"Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай" Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 9 дүгээр тогтоол, 2021 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 278 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого 2022 онд хийхтэй холбогдуулан Дорноговь аймагт буй төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд газрын эрх, авто тээврийн хэрэгслийн тооллогын ажлыг мэргэжлийн байгууллагын мэдээллийн сантай тулган баталгаажуулах, хяналтын үзлэг, тооллого хийж, зөвлөгөө өгөх ажлыг газар дээр нь зохион байгуулах, шалгах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, зардлын төсвийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн хийж гүйцэтгэх ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Холбогдох зардлыг төрийн болон орон нутгийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын батлагдсан зардлаас санхүүжүүлэхийг Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

4.Удирдамжид заасан ажлуудыг 2022 оны 02 дугаар сард багтаан зохион байгуулж, танилцуулахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132003132

ТӨБЗГ тушаал-/2021

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 даргын 2022 оны 2 сарын 14-ны өдрийн 1/2 дугаар
 тушаалын нэгдүгээр хавсралт




**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН УЛСЫН ҮЗЛЭГ,
 ТООЛЛОГЫН БЭЛТГЭЛ ХАНГАХААР, ДОРНОГОВЬ
 АЙМАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
 БҮРЭЛДЭХҮҮН ХУВААРЬ, ЗАРДЛЫН ТӨСӨВ**

төгрөгөөр

Д/д	Аймгийн нэр	Албан тушаал	Ажиллах хүний тоо	Ажиллах хоног /кален дарь/	Томилолтын зардал нэг хүн	Томилолтын зардал нийт	Замын зардал (аймаг хоорондын унаа нэг хүн) Воган	Замын зардал (аймаг хоорондын унаа нийт) Воган	Нийт зардал
1	Дорноговь аймаг	ТӨБАХэлтсийн дарга, мэргэжилтэн	9	3	50,000.00	1,350,000.00	68,500.00	622,900.00	1,972,900.00
	Дүн			3					1,972,900.00

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн
А/12 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



Ажлын хэсгийн удирдамж

Дорноговь аймагт томилолтоор ажиллах Ажлын хэсэг дараах удирдамжийг баримтлан ажиллана.

1. Төрийн өмчит болон Орон нутгийн өмчийн байгууллагын Улсын үзлэг тооллого хийх бэлтгэл ажлын явцтай танилцан мэргэжил алга зүйн туслалцаа үзүүлэн зааварчилгаа өгөх ажлыг Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн газартай хамтран зохион байгуулна.

2. Дорноговь аймагт байгаа төрийн өмчийн нэг, орон нутгийн өмчийн нэг хуулийн этгээдийн автомашины бүртгэлийг “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газартай хамтран газар дээр нь тулган баталгаажилт хийж, зөрчлийг арилгана.

3. Дорноговь аймагт байгаа төрийн өмчийн нэг, орон нутгийн өмчийн нэг хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл дээр Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран газар дээр нь тулган баталгаажилт хийж, зөрчлийг арилгана.

8. Дорноговь аймагт байгаа төрийн өмчийн нэг, орон нутгийн өмчийн нэг хуулийн этгээдийн газрын бүртгэл дээр Газрын харилцаа геодез зураг зүйн газартай хамтран газар дээр нь тулган баталгаажилт хийж, зөрчлийг арилгана.

-----oOo-----